

МАТЕРИАЛ-ИМПЭКС ХК

Санхүүгийн тайлан болон
Хараат бус аудиторын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

АГУУЛГА**ХУУДАС**

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

1

ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

3

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

4

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

5

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

15

АГУУЛГА

ХУУДАС

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДУГНЭЛТ

САНХУУГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

1

ДЭЛГЭРЭНГУЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2

өмчийн өөрчлөлтийн ТАЙЛАН

3

мөнгөн гуйлгээний ТАЙЛАН

4

САНХУУГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

5

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДМ

15

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

КОМПАНИЙН нэр:

Материал Импэкс ХК

ТУЗ-ийн гишүүд:

Дарга

Д.Оюун

Ердийн гишүүд

Б. Зориг
Д.Даваа
Д.Баатардорж
П.Баатарцэрэн
Ш.Ганзориг

Хараат бус гишүүд

Ц.Ариунаа
Б.Энх-Амар
Г.Хонгор

УДИРДЛАГЫН БАГ:

Гуйцэтгэх захирал

Б.Зориг

Санхуу эрхэлсэн захирал

П. Баатарцэрэн

Ерөнхий нягтлан бодогч

Н. Мягмарсүрэн

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Т.Лхагвачулуун



МАТЕРИАЛИМПЭКС

ХУВИЦЛАЛ КОМПАНИ

16010, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг

26-р хороо Үйлдвэрийн төвийн бүс

гудамж, өөрийн байр

Утас: 11-363806, 11-363803

Email: info@materialimpex.mn

Web: www.materialimpex.mn

2025.03.28 № 125

Талай _____ - тал № _____ т

"НИЯМАЗОН АУДИТ" ХХК-д

Удирдлагын хариуцагтын мэдэгдэл

Тус компанийн Гүйцэтгэх захирал Б.Зориг, Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн захирал П.Баатарцэрэн, Ерөнхий нягтлан бодогч Н.Мягмарсүрэн бид энд хавсаргасан санхүүгийн тайлан нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх санхүүгийн байдал, энэ өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн болохы батламжилж байна.



Б.Зориг

Гүйцэтгэх захирал

П.Баатарцэрэн

Санхүү, эрхэлсэн захирал

Н.Мягмарсүрэн

Ерөнхий нягтлан бодогч



МАТЕРИАЛ ИМПЕКС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

NIYAMAZON AUDIT LLC

#408, Building of Trade Union Federation,
Choimbol street, Chingeltei district,
Ulaanbaatar 15172, Mongolia
Tel: (976) 70145906, 91005906
E-mail: audit@nmz.mn

2025.03.28 № А/25-22

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид Материал Импекс ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусвар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Материал Импекс ХК-ийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусвар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу үнэн, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол Улсын Аудитын тухай хуулийн шаардлагын дагуу компаниас хараат бус байж бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайланд хүлээх удирдлагын үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу залилан болон алдаанаас улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэхэд шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага нь компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх ба нөлөөлөх асуудлыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторовн үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторовн тайлан гаргах нь бидний зорилго юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан болон алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандаж, мэргэжлийн итгэл үнэмшил бүхий үнэлэлтийг хийдэг. Бид мөн:

- Залилан болон алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, тохирох аудитын горимыг боловсруулж, дүгнэлтийн үндэслэл болохуйц нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэгтэй холбоотой үүсдэг тул алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.

- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Компанийн үйл ажиллагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд мөн багтдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг талуудын хооронд байгуулсан аудитын ажлын гэрээт захидалд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



З.Цээнээ
Захирал
Ниямазон аудит ХХК

Улаанбаатар хот, Монгол Улс
2025 оны 03 дугаар сарын 28

Материал-Импэкс ХК
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тодруулга		2023 мян.төг	2024 мян.төг
ХӨРӨНГӨ			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3	1,555,317.6	548,842.8
Дансны авлага	4	23,060,839.3	48,564,350.9
Татвар, НДШ-ийн авлага	5	4,096,826.2	2,057,303.3
Бусад авлага	6	1,381,624.3	1,113,333.2
Бараа материал	7	26,626,719.7	26,072,904.3
Урьдчилж төлсөн зардал тооцоо		14,001,948.5	1,843,287.7
Үндсэн хөрөнгө	8	3,776,261.1	15,972,309.7
Биет бус хөрөнгө	9	1,061.7	24,926.9
Урт хугацаат хөрөнгө оруулалт	10	184,471.6	2,684,471.7
НИЙТ ХӨРӨНГӨ		74,685,070.0	98,881,730.5
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Дансны өглөг	11	18,898,135.8	34,206,784.1
Цалингийн өглөг		89,401.1	107,954.6
Татварын өглөг	12	336,735.8	195,825.2
НДШ-ийн өглөг		2,912.9	-
Банкны богино хугацаат зээл		7,000,000.0	7,020,000.0
Урьдчилж орсон орлого		4,850,133.3	9,615,274.9
НИЙТ ӨР ТӨЛБӨР		31,177,318.9	51,145,838.8
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувьцаат		136,820.6	136,820.6
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		3,133,970.5	3,133,970.5
Эздийн өмчийн бусад хэсэг		369,792.7	369,792.7
Хуримтлагдсан ашиг		39,867,167.3	44,095,307.9
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		43,507,751.1	47,735,891.7
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		74,685,070.0	98,881,730.5

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Материал-Импэкс ХК
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛГОСОН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

	Тодруулга	2023 мян.төг	2024 мян.төг
Борлуулалтын орлого	13	53,413,848.3	77,199,031.0
Борлуулалтын өртөг	14	43,264,271.5	66,560,386.7
Нийт ашиг		10,149,576.8	10,638,644.3
Ногдол ашгийн орлого		-	-
Бусад орлого		178,923.3	2,044.1
Ерөнхий ба удирдлагын зардал	15	4,658,379.2	5,714,103.6
Бусад зардал	16	103,496.3	107,055.7
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		(639,637.9)	(74,306.2)
Татварын төлөхийн өмнөх ашиг		4,926,986.7	4,745,222.9
Орлогын татварын зардал		572,096.2	517,082.3
Цэвэр ашиг (алдагдал)		4,354,890.5	4,228,140.6

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмч
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	136,820.6	3,133,970.5	369,792.7	35,922,738.6	39,563,322.4
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	4,354,890.5	4,354,890.5
Зарласан ногдол ашиг	-	-	-	410,461.8	410,461.8
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	136,820.6	3,133,970.5	369,792.7	39,867,167.3	43,137,958.4
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	4,228,140.6	4,228,140.6
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	136,820.6	3,133,970.5	369,792.7	44,095,307.9	47,735,891.7

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

	2023 МЯН.ТӨГ	2024 МЯН.ТӨГ
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	26,283,309.1	25,678,152.4
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	4,306.3	460.6
Бусад мөнгөн орлого	19,813.2	14,429.4
Ажиллагчдад төлсөн	1,569,146.3	1,904,395.3
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	472,600.0	588,000.0
Бараа материал худалдан авахад төлсөн	32,297,415.1	15,904,012.0
Ашиглалтын зардалд төлсөн	102,832.1	122,927.1
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	51,877.6	85,652.0
Хүүний төлбөрт төлсөн	546,074.5	950,652.1
Татварын байгууллагад төлсөн	1,349,840.0	970,887.8
Даатгалын байгууллагад төлсөн	22,924.6	64,819.7
Бусад мөнгөн зарлага	4,741,113.1	3,570,485.7
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(14,846,394.7)	1,531,210.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	14,000.0	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	61,765.3	47,952.7
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	700.0	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	2,500,000.0
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(48,465.3)	(2,547,952.7)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10,500,000.0	9,750,000.0
Бусад орлого	129,228.9	12,286.0
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	3,500,000.0	9,730,000.0
Төлсөн ногдол ашиг	54,448.8	-
Бусад зарлага	131,432.3	22,018.8
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	6,943,347.8	10,267.2
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(7,951,512.2)	(1,006,474.8)
мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	9,506,829.8	1,555,317.6
мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,555,317.6	548,842.8

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

1. Танилцуулга

Материал Импэкс ХК нь /компани/ гадаад орноос болон дотоодын үйлдвэрүүдийн материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг хүлээн авах, хадгалах, хэрэглэгч байгууллагуудад нийлүүлэх буюу барилгын материалын хангалтыг нэгдсэн журмаар бэлтгэн нийлүүлэх үүрэгтэйгээр 1957 онд анх байгуулагдаж, 1999 оноос хувьцаат компанийн статусаар үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагаа:

- Барилгын материалын худалдаа
- Гадаад худалдаа
- Олон улсын тээвэр зуучлал
- Хүнсний бөөний худалдаа

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа:

-Барилга хот, байгуулалтын яамнаас олгосон БА-4.1, БА-6.1, БА-6.2, БА-6.3, БА-6.4 заалтын дагуу ажил, үйлчилгээ эрхлэх, 2027 оны 05 дугаар сарын 09 хүртэл хүчинтэй;

-Зам, тээврийн хөгжлийн яамнаас олгосон төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх, 2025 оны 03 дугаар сарын 21 хүртэл хүчинтэй.

Компанийн нийт хувьцаа 1,368,206 ширхэг ба нийт 1478 хувьцаа эзэмшигчтэй.

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 136,820.6 мянган төгрөг.

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Компанийн Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан заавар, маягтын дагуу бэлтгэгдсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангуудаас бүрдэнэ.

Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, Монгол Улсад мөрдөж буй аудитын хууль тогтоомжийг баримтлан ажилласан. Аудитын дүгнэлт гаргахдаа тус компаниас бидэнд танилцуулсан санхүүгийн баримт, материалд үндэслэсэн болно. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй аливаа баримт материалаас үүсэх хариуцлагыг манай аудитын байгууллага хүлээхгүй юм.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Компанийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу түүхэн өртгөөр бүртгэх тогтсон зарчмыг баримтлан бэлтгэгдсэн ба энэ зарчим нь бодит үнэ цэнээрх тодорхой санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнэ болон бодит үнэ цэнийн үнэлгээн дээр үндэслэн санхүүгийн анхлан хүлээн зөвшөөрөх өөрчлөлтийг тусгасан. Компани өөрийн санхүүгийн байдлын тайланг хөрвөх чадварын дарааллаар толилуулдаг. Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн хураангуйлсан үндсэн бодлогуудыг дор толилуулав. Өөрөөр заагаагүй санхүүгийн тайлагналын хугацааны туршид эдгээр бодлогыг тогтмол баримталдаг.

Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, таамаглалууд

Компанийн санхүүгийн тайланг бэлтгэхийн тулд удирдлага нь санхүүгийн тайланд орлого ба зардал, хөрөнгө ба өр төлбөр, болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, холбогдох тодруулгуудыг бэлтгэхэд шаардлагатай үнэлэмж, таамаглал тооцооллуудыг хийдэг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг зөвхөн нөлөөлж байгаа тайлант үед эсхүл ирээдүйн болон одоогийн тайлант үеүдэд нөлөөлөх бол ирээдүйн болон одоогийн тайлант үеүдэд тус тус тусгадаг.

Тайлангийн мөнгөн тэмдэгт

Эдгээр санхүүгийн тайлангуудыг барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг эдийн засгийн анхдагч орчны мөнгөн тэмдэгт буюу үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлсэн.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь дуусвар хугацаа нь худалдан авч эзэмшснээс хойш 3 сар болон түүнээс богино хугацаагаар тодорхойлогдсон бөгөөд бодит үнэ цэнэ өөрчлөгдөхөд өчүүхэн төдий эрсдлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, компанийн удирдлага богино хугацаат өр төлбөрийг барагдуулах

зорилгоор эзэмшиж буй бэлэн мөнгө болон банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ.

Бараа материал

Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлдог ба бараа материалыг анх олж эзэмшсэн өртгөөр нь бүртгэлд тусгана. Байнгын системээр бараа материалын бүртгэлийг хөтөлж буй үед тайлант үеийн эцэс бүр бараа материалын бүртгэлээр тодорхойлсон дүн нь биет тооллогын дүнгээс зөрүүтэй байвал бараа материалын дүнд залруулах бичилт хийдэг. Хэрэв бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ нь анх олж эзэмшсэн өртгөөс бага тохиолдолд бараа материалын үнэ цэнийн бууралтын гарз үүсэх бөгөөд уг гарзыг тухайн тайлант хугацаанд үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Цэвэр боломжит үнэ цэнэ гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад бараа материалыг худалдан борлуулахаар тооцоолж буй үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүн юм.

Урьдчилгаа төлбөр

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь хараахан гараагүй төлбөр эсвэл хүлээн аваагүй бараа материалын төлбөрөөс бүрдэнэ. Урьдчилгаа төлбөрийг анх өртгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд эсвэл хугацаа дусах үед ашиг, алдагдал руу болон бараа материалыг хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгөнд ангилдаг.

Урьдчилгаа төлбөртэй холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагдах бол урьдчилгаа төлбөрийг санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд эргэлтийн бүс хөрөнгөөр ангилна.

Тайлант жилийн эцэст компани урьдчилгаа төлбөрийн дансны үнэд хяналт тавьж, үнэ цэнийн бууралт гарсан эсэхийг тодорхойлдог.

Үндсэн хөрөнгө

Тайлант хугацаа бүрийн эцэст үйлчилгээ үзүүлэх эсхүл захиргааны зорилгоор эзэмшиж буй барилга болон газраас бүрдсэн үл хөдлөх хөрөнгийг бодит үнэ цэнээс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тусгадаг. Бусад бүх үндсэн хөрөнгө ба тоног төхөөрөмжийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг (хэрэв байгаа бол) хассан дүнгээр тусгадаг.

Үйлчилгээ үзүүлэх эсхүл захиргааны зорилгоор ашиглагдах дуусаагүй барилгыг анхны өртгөөс бүртгэгдсэн үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тусгадаг. Эдгээр дуусаагүй барилгыг ашиглагдах зорилготой нь нийцүүлэн тохирох үндсэн хөрөнгө ба тоног төхөөрөмжийн ангилалд баригдаж дууссан үед нь ангилна. Эдгээр хөрөнгийг ашиглагдах зорилгод хэрэглэх боломжтой болсон үеэс бусад үндсэн хөрөнгүүдийн адил сууриар тооцон элэгдүүлж эхэлнэ.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан дараа үеийн зардал нь тухайн хөрөнгийн анх тооцсон бүтээмжийн түвшинг нэмэгдүүлэх замаар компанид эдийн засгийн ирээдүйн өгөөжийг авчрах магадлалтай үед өртгөөр үндсэн хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлдэг. Бусад бүх худалдан авалтын дараа гарсан зардлуудыг гарсан тайлант үед нь зардлаар бүртгэнэ.

Хөрөнгө тус бүрийн өртгийг үлдэх өртөг хүртэл нь, ойролцоолон тооцоолсон дараах ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

Барилга	25 жил
Тоног төхөөрөмж	10 жил
Тавилга, эд хогшил	10 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Компьютер, техник хэрэгсэл	2 жил

Тооцоолсон ашиглалтын жил, үлдэх өртөг болон элэгдлийг тооцох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл бүртгэлээс хасдаг. Үндсэн хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг, алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг, алдагдалд тусгана.

Биет бус хөрөнгө

Ашиглагдах жил нь тодорхой, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжинэ. Биет бус хөрөнгийн хорогдлыг шулуун шугамын аргаар биет бус хөрөнгийн ашиглалтын жилээр тооцоолон хүлээн зөвшөөрдөг. Тооцоолсон ашиглалтын жил болон хорогдол бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Ашиглагдах жил нь тодорхойгүй, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжинэ.

Биет бус хөрөнгийн ашиглалтын жил нь 2-10 жил байна.

Биет бус хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл бүртгэлээс хасдаг. Биет бус хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг, алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг, алдагдалд тусгана.

Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрүүдийг компани тухайн хэрэглүүртэй холбоотой гэрээт тал болох үед нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх бодит үнэ цэнээр нь бүртгэх ба үүнд гэрээт харилцагчдаас үүссэн дансны авлагыг СТОУС 9-ийн дагуу анх бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр/ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслээс бусад/-ийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг анх бүртгэлд тусгахдаа санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дээр нэмж эсвэл өр төлбөрийн бодит үнэ цэнээс хасаж бүртгэнэ.

Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг тухайн жилийн ашиг, алдагдлаар бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгө

Ердийн журмаар худалдах, худалдан авах санхүүгийн хөрөнгийг бодит гүйлгээ гарсан өдрөөр нягтлан бодох бүртгэлд тусгах эсвэл бүртгэлээс хасдаг.

Ердийн журмаар худалдах, худалдан авах гэдэг нь тогтоосон хугацааны дотор эсвэл тухайн зах зээл дээр тогтсон дүрэм журмаар хөрөнгийг шилжүүлэх нөхцөлөөр санхүүгийн хөрөнгийг худалдах, худалдан авахыг хэлнэ.

Санхүүгийн хөрөнгийг ангиллаас нь хамааран анх бүртгэсний дараа хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэгслүүд нь дараа үеүдэд хорогдуулсан өртгөөр хэмжигдэнэ.

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой бизнесийн загвараар эзэмшдэг болон
- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцөлөөр тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэгслүүдийг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжинэ./БДОБУЦ/

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд эсвэл арилжаалах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилго бүхий бизнесийн загвараар эзэмшдэг болон
- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцөлөөр тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх

Хүүгийн орлогыг тайлант үеийн ашиг, алдагдлаар тайлагнадаг ба санхүүгийн орлого хэсэгт ангилна.

Компани нь зөвхөн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусвар болсон эсвэл санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх ба хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг бусдад шилжүүлсэн үед санхүүгийн хөрөнгийг данснаас хасна. Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийг

данснаас хасахдаа тухайн хөрөнгийн дансны үнэ ба хүлээн авсан дүн болон авлагын нийлбэрийн зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөр ба өмч

Гэрээний зохицуулалтын агуулга болон санхүүгийн өр төлбөр болон өмчийн хэрэгслийн тодорхойлолтын дагуу өр болон өмчийн хэрэгслийг санхүүгийн өр төлбөр эсвэл өмч гэж ангилдаг.

Өмчийн хэрэгсэл

Компанийн бүх хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгээс хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэдэг. Группээс гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжиж бүртгэдэг.

Энгийн хувьцаа

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын аливаа нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

Хувьцаат капиталыг буцаан худалдан авах /халаасны хувьцаа/

Хувьцаат капиталыг буцаан худалдан авсан үед аливаа татаврын нөлөөллийн дараах худалдан авахтай холбоотой гарсан шууд зардлыг багтаасан дүнгээр эздийн өмчийн бүртгэл гэж бүртгэдэг.

Буцаан худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж нэрлэх бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланд халаасны хувьцаа гэж тайлагнадаг.

Хувьцаат хувьцааг дахин борлуулсан эсвэл дахин эргэлтэнд гаргасан үед хүлээн авсан дүнг өмчийн өсөлтөөр бүртгэдэг бөгөөд тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан өсөлт, бууралтыг нэмж төлөгдсөн капитал гэж толилуулдаг.

Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг нь компанийн өмчийн эздэд ногдох ашгаас зарлсан ногдол ашгийг хассан дүн болно. Стандартад шилжилтийн шаардлагын дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөс үүссэн нөлөөллийг хуримтлагдсан ашигт бүртгэдэг.

Эздийн оруулсан хөрөнгө оруулалт

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс өмнө болон бусад мөнгөн бус хөрөнгөөр сайн дурын үндсэн дээр оруулсан хөрөнгө оруулалт нь тухайн хөрөнгийн бодит үнэ цэнээр эздийн өмчид шууд бүртгэгддэг.

Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц

Хөрвүүлэлтийн нөөц нь гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайлангийн хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүү болон компанийн гадаадын охин компанид оруулсан цэвэр хөрөнгө оруулалтыг хэйджинг хийсэн өр төлбөрийн хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын хашийн зөрүүнээс бүрдэнэ.

Санхүүгийн өр төлбөр

Бүх санхүүгийн өр төлбөрийг анх бүртгэсний дараа үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Компанийн санхүүгийн өр төлбөр нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хэрэгслүүдээс бүрддэг.

Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцож холбогдох хугацааны туршид хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр /үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан/-ийг санхүүгийн өр төлбөрийн хугацааны туршид эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хорогдуулахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

Санхүүгийн өр төлбөрийг данснаас хасах

Компани нь санхүүгийн өр төлбөрийг гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд данснаас хасна. Данснаас хасаж буй санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба төлсөн дүн болон өглөгийн нийлбэрийн зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Орлого хүлээн зөвшөөрөлт

Бараа борлуулсны орлого, хөрөнгөө бусдад ашиглуулсны болон үйлчилгээ үзүүлсний орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр нь хэмжих ба гарсан аливаа худалдаа, үйлчилгээний буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралт зэргийг хассан цэвэр дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.

Үйлчилгээ үзүүлсний орлого

Үйлчигээний орлогод гэрээгээр гүйцэтгэсэн үйлчилгээний орлого хамаарна. Эдгээр орлогууд нь үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд орлогоор хүлээн зөвшөөрөгдөнө.

Үйлчилгээнээс орох орлогыг тухайн ажил гүйлгээний тайлагналын өдрөөрх гүйцэтгэлийн үйл явцтай нь уялдуулан ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үйлчилгээний гүйцэтгэлийн үйл явцыг гүйцэтгэсэн ажилд хийсэн судалгаанд үндэслэн үнэлдэг.

Бараа борлуулалтын орлого

Компани барааны өмчлөлтэй холбогдон үүсэх мэдэгдэхүйц эрсдэл эсвэл өгөөжийг худалдан авагч талд шилжүүлсэн, борлуулсан барааныхаа өмчлөлд холбогдох аливаа удирдлагын болон хяналтын үүргийг өөртөө хадгалаагүй, орлогын дүнг найдвартай хэмжих боломжтой, тухайн ажил гүйлгээний эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлалтай бөгөөд тухайн ажил гүйлгээтэй уялдаж гарсан ба цаашид гарах зардлыг найдвартай хэмжин тодорхойлж болохоор байгаа үед орлогыг хүлээн зөвшөөрдөг.

Гадаад валютын ажил гүйлгээ

Компанийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн тайлагналын валютаас бусад валютыг (гадаад валют) ажил гүйлгээ гарсан өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэсэн.

Төгрөгөөс бусад мөнгөн тэмдэгт нь гадаад валют гэж тооцогддог ба гадаад валютаар хийгдсэн гүйлгээнүүдийг тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар төгрөг рүү хөрвүүлдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө, хөрөнгө болон өр төлбөрүүдийн гүйлгээ хийгдсэн өдрөөс хойших ханшийн өөрчлөлтөөс үүсэн гарах өөрчлөлтийг гарсан цаг хугацаанд нь ашиг алдагдлаар бүртгэнэ.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн хөрөнгө ба өр төлбөрийг тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар хөрвүүлдэг. Ханшийн зөрүүнээс үүссэн зөрүүг орлогын дэлгэрэнгүй тайланд тусган эздийн өмчийн хэсэгт хуримлуулан бүртгэнэ.

Зардал хүлээн зөвшөөрөлт

Зардлыг орлогын дэлгэрэнгүй тайланд зардлын чиг үүргийн аргыг ашиглан тайлагнадаг. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт борлуулсан барааны бүтээгдэхүүнтэй шууд холбоотой зардлууд багтдаг. Компанийн үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын, борлуулалт ба маркетингийн болон бусад бизнесийн үйл ажиллагааны зардлууд ордог.

Санхүүгийн орлого ба санхүүгийн зардал

Санхүүгийн орлого нь хүүгийн орлого ба ногдол ашгийн орлогоос бүрдэх ба ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөн бүртгэлд тусгагддаг. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан орлогын тайланд хуримтлуулан хүлээн зөвшөөрдөг. Ногдол ашгийн орлогыг Компанид ногдол ашиг хүлээн авах эрх үүссэн үед нь хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрдэх ба ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөн бүртгэлд тусгагддаг. Шалгуурт нийцсэн хөрөнгийн олж бэлтгэх, барьж байгуулах ба үйлдвэрлэхэд шууд холбоотой хүүгийн зардлыг тэдгээр хөрөнгийн өртөгт оруулж бүртгэдэг. Шалгуурт нийцсэн хөрөнгө гэдэг нь түүнийг зориулалтаар нь ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход их хэмжээний хугацаа зарцуулдаг хөрөнгийг хэлэх ба уг хөрөнгийг ашиглах ба борлуулахад бэлэн болгох хүртэлх хугацаанд хүүгийн зардлыг хөрөнгийн өртөгт оруулдаг.

Зориулалт нь тодорхой зээлийг холбогдох хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж эхлэх хүртэл эсвэл борлуулахад бэлэн болсон нь тодорхой болсон үед зээлийг ерөнхий зээлийн капиталжуулалтын түвшинг тооцох зорилгоор зээлийн ерөнхий санд байлгадаг. Тодорхой зээлийг түр хугацаагаар хөрөнгө оруулалт хийх зорилгоор олж авсан хөрөнгө оруулалтын орлого нь шаардлага хангасан хөрөнгөнд зарцуулагдах хүртэл

хүлээгдэж байна. Зээлийн хүүгийн зардлаас хасаж хөрөнгийн зориулалт нь тодорхой зээлээрх түр хөрөнгө оруулалтаас олсон хөрөнгө оруулалтын орлогын зарцуулалтыг зээлийн өртгөөс хасаж капиталжуулан хөрөнгийн өртөгт бүртгэнэ.

Орлогын татвар

Орлогын татварын зардал нь тайлант үеийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Орлогын татварын зардлыг өмчийн дансанд шууд хүлээн зөвшөөрдөг зүйлстэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Тайлант үеийн татвар гэдэг нь өмнөх жилүүдийн татварын өрийн тохируулга болон тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эсвэл мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээг ашиглан тухайн жилийн татвар ногдох ашиг, татварын алдагдалд суурилан хүлээгдэж буй татварын өр эсвэл авлага юм.

Татвар ногдох орлого бий болох нь тодорхой болсон бүх татвар ногдох түр зөрүүнд хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрдөг. Тайлант үеийн эцсээр хүчин төгөлдөр болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээ (татварын хууль)-нд үндэслэсэн хөрөнгө нь хэрэгжих буюу өр төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварыг хэмждэг.

Компани тайлант жилийн болон хойшлогдсон татварын дүнг тодорхойлохдоо татвартай холбоотой тодорхойгүй нөхцөл байдал, нэмэлт татвар болон хүү төлөгдөх магадлал гэх мэт хүчин зүйлсийн нөлөөг тооцож үздэг. Татварын хууль тогтоомжийн тайлбар, өмнөх жилүүдийн туршлага гэх мэт олон хүчин зүйлсийг үнэлсний үндсэн дээр компани татварын өр төлбөрөө нээлттэй татварын жилүүдэд хангалттай хэмжээнд хуримтлуулсан гэж үзэж байна. Энэхүү үнэлгээ нь компанийн ирээдүйн үйл явдлын талаарх тооцоолол, таамаглал болон олон хувилбарт үнэлэмжинд үндэслэдэг. Одоогийн хуримтлуулсан татварын өр төлбөрийн хангалттай байдлын талаарх компанийн үнэлэмжинд нөлөө үзүүлж болохуйц шинэ мэдээлэл, нөхцөл байдал үүсч болох юм. Энэхүү нөлөө нь тухайн өр төлбөрийг тодорхойлсон тайлант хугацааны татварын зардалд нөлөөлнө.

Компани хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн цэвэр дүнг гаргах хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй бөгөөд түүнд ногдуулсан татварыг тухайн компанийг хариуцсан татварын байгууллагаас ногдуулсан тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр тайлагнаж болно. Ашиглагдаагүй татварын алдагдал, хөнгөлөлт болон татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүүг тэдгээрийг ашиглаж болохуйц хэмжээний ирээдүйн татвар ногдох орлого олох нь магадлалтай хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгөөр хүлээн зөвшөөрдөг.

Материал-Импэкс ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	(мян.төг)	
Ангилал	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
Бэлэн мөнгө		
Кассанд байгаа бэлэн мөнгө	58,688.6	1,383.5
Кассанд байгаа бэлэн доллар	1,103,252.8	135,430.0
Кассанд байгаа бэлэн юань	1,662.5	2,544.2
Кассанд байгаа бэлэн рубль	4,301.9	6,888.6
Дүн	<u>1,167,905.8</u>	<u>146,246.3</u>
Банкин дахь харилцах		
Төрийн банк /төгрөг/	121.2	108.2
Төрийн банк /юань/	3.7	3.6
Хаан банк /төгрөг/	37,604.9	6,213.4
Хаан банк /төгрөг/	177.8	8.8
Хаан банк /доллар/	198,985.1	15,135.8
Хаан банк /юань/	647.7	608.4
Хаан банк /рубль/	3,012.1	2,558.5
Худалдаа хөгжил /төгрөг/	22,896.2	581.9
Худалдаа хөгжил /доллар/	6,369.0	13,460.2
Хас банк /төгрөг/	16,763.5	25.1
Хас банк /доллар/	18,278.5	18,289.9
Голомт банк /төгрөг/	43,409.2	39,570.4
Голомт банк /төгрөг ЖМС/	1,110.0	3,239.8
Голомт банк /төгрөг/	15.0	3.0
Голомт банк /доллар/	1,095.4	271,049.8
Голомт банк /юань/	32,539.4	27,644.0
Голомт банк /евро/	3,963.8	3,711.0
ХХБанк /доллар/	183.0	168.4
ХХБанк /юань/	34.5	14.0
Харилцах /төгрөг/	19.0	19.0
Харилцах /төгрөг/	43.0	43.0
Харилцах /доллар/	139.8	140.3
Дүн	<u>387,411.8</u>	<u>402,596.5</u>
Нийт дүн	<u>1,555,317.6</u>	<u>548,842.8</u>

4. ДАНСНЫ АВЛАГА

	(мян.төг)	
Ангилал	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
Эхний үлдэгдэл	16,680,973.6	23,060,839.3
Нэмэгдсэн	77,953,336.7	110,348,493.4
Хасагдсан	71,573,471.0	84,844,981.8
Нийт дүн	<u>23,060,839.3</u>	<u>48,564,350.9</u>

5. ТАТВАРЫН АВЛАГА

	(мян.төг)	
Ангилал	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
Нэмэгдсэн өртгийн албан татварын	4,095,379.1	2,048,211.2
Хувь хүний орлогын албан татварын	1,428.3	-
Нийгмийн даатгалын шимтгэлийн	-	9,073.3
Бусад татварын авлага	18.8	18.8
Нийт дүн	<u>4,096,826.2</u>	<u>2,057,303.3</u>

6. БУСАД АВЛАГА

	(мян.төг)	
Ангилал	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
Ажилчдаас авах авлага	1,120,266.1	857,856.9
Богино хугацаат авлагын бичиг	261,358.2	255,476.3
Нийт дүн	<u>1,381,624.3</u>	<u>1,113,333.2</u>

Материал-Имплэкс ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

7. БАРАА МАТЕРИАЛ

Ангилал	(мян. төг)		(мян. төг)			
	Дуусаагүй үйлдвэрлэл	Бараа	Нийт дүн	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл
2024 оны 1 сарын 1	49,660.7	26,577,059.0	26,626,719.7	1,942,634.3	110,991.8	132,597.0
Нэмэгдсэн	990,735.9	32,372,147.2	33,362,883.1	-	5,691.6	46,611.1
Хасагдсан	990,735.9	32,925,962.6	33,916,698.5	-	116,683.4	179,208.1
2024 оны 12 сарын 31	49,660.7	26,023,243.6	26,072,904.3	1,942,634.3	116,683.4	179,208.1

8. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Ангилал	Барилга байгууламж	Машин тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Нийт дүн
Анхны өртөг							
2024 оны 1 сарын 1	6,054,140.4	268,533.6	1,942,634.3	110,991.8	132,597.0	814.3	8,509,711.4
Нэмэгдсэн	12,665,058.5	-	-	5,691.6	46,611.1	-	12,717,361.2
2024 оны 12 сарын 31	18,719,198.9	268,533.6	1,942,634.3	116,683.4	179,208.1	814.3	21,227,072.6
Хүримтлагдсан элэгдэл							
2024 оны 1 сарын 1	3,102,804.4	240,309.1	1,243,974.6	64,737.5	81,624.7	-	4,733,450.3
Тайлант онд байгуулсан элэгдэл	295,347.6	12,433.7	167,880.5	5,974.3	39,676.5	-	521,312.6
2024 оны 12 сарын 31	3,398,152.0	252,742.8	1,411,855.1	70,711.8	121,301.2	-	5,254,762.9
Дансны үнэ	15,321,046.9	15,790.8	530,779.2	45,971.6	57,906.9	814.3	15,972,309.7

9. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Ангилал	(мян. төг)	
Компьютерийн програм хангамж	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
Нэмэгдсэн дүн	7,300.0	8,000.0
2024 оны 12 сарын 31	700.0	24,110.2
Хүримтлагдсан хорогдол	8,000.0	32,110.2
Эхний үлдэгдэл	6,343.3	6,938.3
Байгуулсан хорогдол	595.0	245.0
2024 оны 12 сарын 31	6,938.3	7,183.3
Дансны үнэ	1,061.7	24,926.9

Материал-Импэкс ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар
9. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	2023 оны 12 сарын 31	(мян.төг) 2024 оны 12 сарын 31
Ангилал		
Компьютерийн программ хангамж	7,300.0	8,000.0
Нэмэгдсэн дүн	700.0	24,110.2
2024 оны 12 сарын 31	8,000.0	32,110.2
Хуримтлагдсан хорогдол		
Эхний үлдэгдэл	6,343.3	6,938.3
Байгуулсан хорогдол	595.0	245.0
2024 оны 12 сарын 31	6,938.3	7,183.3
Дансны үнэ	1,061.7	24,926.9

10. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2023 оны 12 сарын 31	(мян.төг) 2024 оны 12 сарын 31
Ангилал		
Хөрөнгө оруулалт /МИК ХХК/	184,471.6	61,043.7
Хөрөнгө оруулалт бусад	-	123,428.0
Хөрөнгө оруулалт /Материал кредит ББСБ/	-	2,500,000.0
Нийт дүн	184,471.6	2,684,471.7

11. ДАНСНЫ ӨГЛӨГ

	2023 оны 12 сарын 31	(мян.төг) 2024 оны 12 сарын 31
Ангилал		
Төлөгдөх хугацаандаа байгаа	18,898,135.8	34,206,784.1
Нийт дүн	18,898,135.8	34,206,784.1

12. ТАТВАРЫН ӨР

	2023 оны 12 сарын 31	(мян.төг) 2024 оны 12 сарын 31
Ангилал		
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын	272,117.5	140,243.7
Хувь хүний орлогын албан татварын	64,603.9	55,539.1
Бусад татварын өр	14.4	42.4
Нийт дүн	336,735.8	195,825.2

13. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

	2023 оны 12 сарын 31	(мян.төг) 2024 оны 12 сарын 31
Ангилал		
Бараа борлуулсны орлого	15,420,331.1	77,199,031.0
Үйлчилгээ үзүүлсний орлого	37,993,517.2	-
Нийт дүн	53,413,848.3	77,199,031.0

14. БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ

	2023 оны 12 сарын 31	(мян.төг) 2024 оны 12 сарын 31
Ангилал		
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	43,264,271.5	66,560,386.7
Нийт дүн	43,264,271.5	66,560,386.7

Материал-Импэкс ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

15. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

	(мян.төг)	
Ангилал	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
Ажиллагчдын цалин	1,944,223.4	2,371,158.0
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн	255,103.9	310,657.4
Албан татвар, төлбөр, хураамжийн	36,028.3	20,446.3
Томилолт	22,993.2	-
Бичиг хэрэг	5,178.1	-
Шуудан холбоо	15,600.5	20,130.8
Мэргэжлийн үйлчилгээ	-	98,441.1
Сургалт	1,470.0	1,926.0
Даатгал	22,924.6	64,819.7
Ашиглалтын зардал	119,922.3	134,437.3
Засварын зардал	315,556.6	-
Элэгдэл хорогдлын зардал	484,619.5	521,557.6
Цэвэрлэгээ үйлчилгээ	26,329.9	32,769.0
Шатахууны зардал	58,930.2	60,420.8
Зар сурталчилгаа	7,475.5	19,003.3
Хөдөлмөр аюулгүй байдал	53,640.7	-
Бусад	1,288,382.5	2,058,336.3
Нийт дүн	4,658,379.2	5,714,103.6

16. БУСАД ЗАРДАЛ

	(мян.төг)	
Ангилал	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
Алданги, торгуулийн зардал	3,000.0	4,000.0
Хандивын зардал	-	10,606.4
Үйл ажиллагааны бус бусад	100,496.3	92,449.3
Нийт дүн	103,496.3	107,055.7

17. ХУВЬЦАА

Хувьцаа эзэмшигч	Эзэмшиж буй хувь	Хувьцааны тоо
Д.Тунгалаг	7.25	99,192.0
З.Тогос	10.54	144,272.0
З.Цолмон	11.36	155,468.0
Б.Зориг	56.17	768,564.0
Бусад	14.68	200710
Нийт дүн	100.0	1,368,206.0

18. ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ

Тайлант хугацаанд холбоотой талуудтай гүйлгээ хийсэн ба эдгээр нь санхүүгийн тайланд тусгагдсан, зохих тодруулга хийгдсэн.

19. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Тус компанид 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар болзошгүй өр төлбөр байхгүй байна.

20. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ

Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан гарснаас хойш санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхүйц үйл явдал гараагүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Аудитын байгууллага нь санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

1. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Өгсөн зөвлөмж:

Өмнөх оны эцсийн үлдэгдэлтэй харьцуулбал дансны авлага 1 дахин нэмэгдэж, богино хугацаат өр төлбөр 61 хувиар өссөн, мөнгө хөрөнгийн үлдэгдэл 1.0 тэрбум төгрөгөөр буурсан байна. Борлуулалтын орлого 23.8 тэрбум төгрөгийн нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа боловч цэвэр ашиг борлуулалтын орлогын 8.1 хувийг эзэлж байсан бол тайлант онд 5.4 хувь болон буурсан байна. Ашгийн түвшин тогтвортой байгаа боловч зардлын өсөлт, авлага, өрийн өсөлтөд дүн шинжилгээ хийж, дотоод хяналтыг сайжруулах

2. Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч хариуцах бөгөөд жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө, эд хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солилцох үед, эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулинд заасан бусад тохиолдолд хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийж байх

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг мөрдөж ажиллах

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх нь компанийн удирдлагын хариуцлага бөгөөд зохистой нягтлан бодох бүртгэл болон дотоод хяналтын системийг бий болгох, бүртгэлийн бодлогыг сонгох ба хэрэглэх зэрэг багтдаг. Дотоод хяналт гэдэг нь байгууллагын зорилгод хүрэх, үйл ажиллагааны үр ашигтай байдлыг хангах, санхүүгийн тайлангийн найдвартай байдлыг хангах, хууль, дүрэм журмыг мөрдөхөд чиглэсэн удирдлагын хэрэгжүүлдэг бодлого, үйл ажиллагааны цогц тогтолцоо юм. Аудитаар компанийн дотоод хяналтыг үнэлэх үйл явц учир дутагдалтай байсан тул цаашид анхаарч ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.